



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 188


Улаанбаатар хот

“Жэтфинанс ББСБ” ХХК-ийн
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жэтфинанс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор хийлгэхийг “Жэтфинанс ББСБ” ХХК /З.Мөнхзаяа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг болон олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН